



МОНГОЛ УЛС  
МОНГОЛБАНК

Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71,  
Цахим хуудас: www.mongolbank.mn

2026.03.31 № А-1/243  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Г.ЛУВСАНЖАМЦ ТАНАА

Таны ирүүлсэн 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 12 тоот албан бичгээр Монгол Улсын Их Хурлын 2025 оны “Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайлан, үр дүнг үнэлсэн дүгнэлт болон шаардлагатай бусад мэдээллийг авах тухай хүсэлттэй танилцлаа.

Дээрх тогтоолд тусгагдсан ногоон зээлийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайлан, үр дүнг үнэлсэн дүгнэлтийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 7 хуудастай.

Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙЛӨГЧ

С.НАРАНЦОГТ

1526030636

2026 оны 3 дугаар сарын 31 өдрийн А-1245 дугаар  
албан бичгийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ 6 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДРИЙН  
"НОГООН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ  
САЙЖРУУЛАХ ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ" 57 ДУГААР  
ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН БОЛОН НЭМЭЛТ АСУУЛГУУДЫН  
ХАРИУЛТУУД

1. Ногоон зээлийн ангилал, шалгуурыг олон улсын жишиг, стандарттай уялдуулан шинэчлэх, ногоон санхүүжилтийн тайлагнал, ил тод байдал, хяналт-шинжилгээний тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр Монголбанкнаас ямар бодлого, зохицуулалт, журам, арга хэмжээг бодитоор хэрэгжүүлсэн, өнөөдрийн байдлаар мөрдөж буй ногоон зээлийн ангилал, шалгуур нь олон улсын ямар стандарт, таксономитой уялдаж байгаа, эдгээр шалгуур нь арилжсааны банкнуудын зээлийн бодлогод хэрхэн тусгагдаж, практикт бодитоор хэрхэн хэрэгжиж байгаа болон олон нийтэд хэрхэн ил тод хүргэж байгаа талаарх тоон үзүүлэлт, бодит мэдээлэл бүхий нэгдсэн тайлан, мэдээлэл;

*Биелэлт:* Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс банк, санхүүгийн салбарын тогтвортой хөгжил, ногоон санхүүжилтийн үйл ажиллагааг дэмжих бодлогын хүрээнд 2019 онд Монгол Улсын “Ногоон таксономи”-ийг баталсан. Энэхүү таксономийн дагуу Монголбанк банкнуудаас ногоон зээлийн тайлан авч эхэлснээр Монгол Улсын Ногоон, тогтвортой санхүүжилтийн хувьд ихээхэн ахиц дэвшил гарсан. Ингэснээр дата мэдээллийн сан үүсэх, аливаа судалгаа шинжилгээ хийх, түүнээс гарах үр дүнд тулгуурлан аливаа бодлогын шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлсэн.

“Ногоон таксономи”-ийг үндэслэн илүү өргөн хүрээний хүртээмжтэй, илүү нарийн шалгуур бүхий “Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи” (ТХЗ таксономи)-ийг 2026 оноос хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү таксономиг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2023 онд баталж, уг таксономийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл туршилтын журмаар нэвтрүүлэн, хэрэгжилтийн явцад шаардлагатай сайжруулалтыг хийхээр тусгасан. Банкнууд болон Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ТоС холбоо)-оос ирүүлсэн хүсэлтийн дагуу туршилтын хугацааг 2026 оны I улирал хүртэл сунгаад байна. Дээрх таксономиудыг олон улсын холбогдох стандартууд болон сайн туршлагаудтай нийцсэн байхаар боловсруулж, баталсан. “SDG таксономи”-ийн ангилал бүрийн хувьд холбогдох үндэсний болон салбарын дүрэм, журам, стандарт болон олон улсад зөвшөөрөгдсөн стандартыг тус тус тусгасан. Одоогоор Монголбанк нь “ТХЗ таксономи”-ийг шинэчлэх чиглэлээр ТоС холбоо, банкнууд болон холбогдох яамнуудтай хамтран ажиллаж байна.


"Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй санхүүгийн эрсдэлүүдэд Монгол Улсын банкны салбарын өртөмтгий байдлын үнэлгээ"-ний тайланг Монголбанк, Дэлхийн банктай хамтран гаргасан ба тус тайлангаар Монгол Улсын банкны салбарын уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй (1) Биет болон (2) Шилжилтийн эрсдэлд өртөмтгий байдалд тухайн хугацааны тасалбар байдлаар үнэлгээг хийж гүйцэтгэлээ.<sup>1</sup>

Ногоон зээлийн ангилал, шалгуурт хяналт шинжилгээг хийхэд одоогоор хэмжилт, тайлагнах, баталгаажуулах тогтолцоо нь бүрдээгүй байгаа ба Уур амьсгалын өөрчлөлтийн тухай анхдагч хуулийн төсөлд ногоон санхүүжилт, түүний хөшүүрэг, зохицуулалтын хүрээнд хуульчлан тусгасан байна. Цаашид хууль батлагдахад дагаж мөрдөх журам, зааврыг боловсруулж, хяналт тавин ажиллахаар байна.

2. Арилжааны банкнуудын ногоон зээлийн тайлан гаргалт, бүрдүүлэлт мэдээллийн чанар, шалгуурыг сайжруулах чиглэлээр хийсэн хяналт шалгалт, үнэлгээ, хяналт шинжилгээний явцад илэрсэн нийтлэг зөрчил, дутагдал, тэдгээрийг арилгах хүрээнд Монголбанкнаас авсан бодит арга хэмжээ, чанарт гарсан ахиц, өөрчлөлт зэргийн талаарх тоон үзүүлэлт, баримтад тулгуурласан тайлан, мэдээлэл;

Биелэлт: Банкнуудын ногоон зээлийн тайланг 2019 оны 4 дүгээр улирлаас эхлэн улирал тутам зээлийг сегментчлэн мөн чанарын ангилал, зээлийн тоо, жигнэсэн дундаж хүү зэрэг мэдээллийг цуглуулан нэгтгэж, ногоон зээлийн үзүүлэлтүүдээр dashboard буюу хяналтын самбарын танилцуулга бэлтгэж, олон нийтэд танилцуулж байна<sup>2</sup>.

Зураг1. Банкны салбарын ногоон зээлийн статистик мэдээ



Эх сурвалж: Монголбанк


Банкнуудын ногоон зээл 2025 оны 12 дугаар сарын байдлаар 2,334.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 981.3 тэрбум төгрөгөөр буюу 72.5 хувиар өсжээ. Энэ нь нийт

<sup>1</sup> <https://www.mongolbank.mn/mn/p/1601>

<sup>2</sup> Цахим холбоос: [Монголбанк Статистик - Мөнгө санхүүгийн статистик](#),

банкнуудын зээлийн 5.3 хувийг эзэлж байгаа бөгөөд үйл ажиллагааны салбараар нь задалбал, ногоон зээлийн 61.1 хувь нь эрчим хүчний хэмнэлтийн салбарт, 15.3 хувь нь тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт, ой болон эко аялал жуулчлалын салбарт, 7.6 хувь нь карбон бага тээвэрт олгогджээ. Мөн нийт ногоон зээлийн 3.1 хувь нь анхаарал хандуулах, 2.2 хувь нь чанаргүй зээл байна.

Зураг 2. Банкны салбарын ногоон зээлийн тайлан



Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2019 оны 12 дугаар сард “Ногоон таксономи” баталсан өдрөөс өнөөг хүртэл буюу 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар банкны салбарын ногоон зээлийн үлдэгдэл 5.5 дахин, зээлийн тоо 4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Монголбанкнаас олон улсын байгууллагууд болох Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ази, Номхон далайн бүсийн Эдийн засаг, нийгмийн комисс (ESCAP) болон Олон улсын санхүүгийн корпораци (IFC)-тай хамтран “Төв банкнийг ногооруулах бэлэн байдалд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС S1, S2) -д нийцүүлэн санхүүгийн салбарт зориулсан удирдамжийг боловсруулж, нээлтийн үйл ажиллагааг 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр банк санхүүгийн салбарын удирдлагууд болон холбогдох ажилтнуудыг оролцуулан хийсэн<sup>3</sup>. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн А-180 дугаар тушаалаар удирдамжийг батлан гаргалаа<sup>4</sup>.

Тус удирдамжийг банкнуудын тайлагналд нэвтрүүлэх нь Монгол Улсын санхүүгийн салбарт ил тод, тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн чухал алхам болсон бөгөөд хөрөнгө оруулагчид болон бусад оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлэх, уур амьсгалын нөлөөллийг ил тод тайлагнах үйл явцын эрчимжүүлэх, олон улсад Монгол Улсын санхүүгийн салбарын нэр хүндийн эрсдэл болон ногоон угаалт (green washing)-ын


<sup>3</sup> <https://www.mongolbank.mn/mn/r/9482>

<sup>4</sup> <https://www.mongolbank.mn/mn/r/10162>

эрсдэлийг бууруулах, банк, санхүүгийн салбарын уур амьсгалын нөлөөллийн тайлагналын тухай ойлголтын ялгаатай байдлыг арилгах зэрэг нөхцөлүүд бүрдэх юм.

Удирдамжид банкнууд тайлагнах явцдаа суралцах буюу СТОУС S1, S2 стандартуудыг бүрэн нэвтрүүлэхэд шаардлагатай өгөгдөл мэдээллийг цуглуулах, дотооддоо мөрдөх тайлагналын арга аргачлалыг боловсруулах, ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх, зохицуулагч байгууллагын тайлангийн хяналтын үйл ажиллагааг сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх үе шаттай замын зургийг тусгасан. Энэ хүрээнд нийт банк, санхүүгийн байгууллагууд 2032 оноос эхлэн уур амьсгалын нөлөөллийн СТОУС S1, S2 стандартуудын дагуу бүрэн хэмжээнд тайлагнадаг болно.<sup>5</sup>

Зураг 3. СТОУС S1, S2 стандартыг хэрэгжүүлэх замын зураг (2025-2032)



Монголбанк болон Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ази, Номхон далайн бүсийн Эдийн засаг, нийгмийн комисс (UNESCAP) хамтран хэрэгжүүлж буй “Төв банкныг ногооруулах бэлэн байдалд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн хүрээнд UNESCAP-аас Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны А-31 дүгээр тушаалаар баталсан “Банкны байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийг үнэлэх, удирдах аргачлал”-ын хэрэгжилт, тайлагналын зохицуулалтад үнэлгээ хийж Монгол Улсын Байгаль орчин, нийгэм засаглал (БОНЗ)-ын талаарх хэлэлцүүлгийн баримт бичгийг боловсруулсан.

Уг баримт бичгээр Монгол Улс БОНЗ-ын зохицуулалтын дэд бүтцийг бүрдүүлж эхэлсэн ч олон улсын стандартад бүрэн нийцүүлэхийн тулд хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх, эрсдэлийг үнэлэх тоон аргачлал, чадавхыг сайжруулах, нэгдсэн БОНЗ-ын өгөгдлийн дэд бүтэц хөгжүүлэх, цахим мэдээлэл цуглуулах нэгтгэсэн платформ нэвтрүүлэх зэрэг чиглэлүүдэд анхаарч ажиллах шаардлагатай байгааг зөвлөсөн байна.

<sup>5</sup> <https://www.mongolbank.mn/mn/p/1601>

Түүнчлэн Монголбанкнаас 2025 оны 8 дугаар сард “Уур амьсгалын сценари шинжилгээ 2024-2025”-г хийж гүйцэтгэсэн ба баримт бичиг нь Монголбанкаас 2024 оны аравдугаар сараас 2025 оны долоодугаар сар хүртэл банкны салбарын анхны уур амьсгалын сценарийн шинжилгээ (CSA)-г хэрэгжүүлсэн үр дүнг танилцуулсан. Тайланд зээлийн эрсдэлийн өртөлт, санхүүжүүлсэн ялгарлын тоон үнэлгээнүүдийг төдийгүй банкны салбар дахь уур амьсгалын эрсдэлийн удирдлагын өнөөгийн байдлын чанарын дүн шинжилгээг багтаасан.<sup>6</sup>

Банкны байгаль орчин, нийгэм, засаглалын үнэлгээний аргачлал, уур амьсгалын сценарийн шинжилгээ, стресс тестийн загвар, санхүүгийн салбарын эрсдэлд өртөмтгий байдлын үнэлгээ, мөнгөний бодлого болон макро эдийн засагт уур амьсгалын нөлөөллийн судалгаа зэрэг чиглэлээр баримт бичгүүдийг олон улсын санхүүгийн байгууллагуудаас техник туслалцаа авч, хамтран боловсруулж, тэдгээрийн үр дүн болон уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн тооцооллыг Монголбанкны бодлогын шийдвэр гаргалт, банкны салбарын хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход ашиглах суурийг бэлтгэж байна. Монголбанкны газар, нэгжүүд өөрийн хариуцсан чиглэлийн хүрээнд ногоон зээлийн асуудлыг хариуцан ажиллаж байсныг бие даасан тогтвортой хөгжил, ногоон санхүүжилтийн бодлогын хэлтэс байгуулж, хариуцан ажиллахаар зохион байгуулаад байна. Цаашид тайлан гаргалт, бүрдүүлэлт мэдээллийн чанар, шалгуурыг сайжруулах чиглэлээр банканд хяналт, шалгалт хийх, үнэлэлт дүгнэлт гарган, хамтран ажиллахаар төлөвлөж байна.

3. Ногоон зээлийн хүүгийн түвшинг бодитоор бууруулах, иргэн, аж ахуйн нэгжид хүртээмжтэй болгох зорилгоор гадаад валютаар хийгдэх своп хэлцэл болон бусад мөнгөний бодлогын хэрэгслээр дамжуулан Монголбанкнаас ямар бодлого, зохицуулалт, арга хэмжээг бодитоор хэрэгжүүлсэн, эдгээр бодлогын шийдвэрүүд бодит зах зээл дээр хэрхэн нөлөөлж, арилжааны банкнуудын ногоон зээлийн нөхцөл, санхүүжилтийн өртөг, эрсдэлийн үнэлгээнд ямар өөрчлөлт авчирсан талаар нэгдсэн тайлан, мэдээлэл;

*Биелэлт:* Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А-162 дугаар тушаалаар Урт хугацаат своп хэлцэл (УХСХ)-ийн журмыг шинэчлэн баталсан. Тус журамд банк ногоон таксономийн ангилалд багтсан эх үүсвэрээр своп хэлцэл байгуулах тохиолдолд свопын зардлыг 0.5 хувиар хөнгөлөх тухай заалтыг оруулж, ногоон санхүүжилтийг дэмжих тогтолцоог бүрдүүлсэн. Энэхүү зохицуулалтын хүрээнд 2021 оноос 2025 оны 04 дүгээр сар<sup>7</sup> хүртэл нийт 520.3 сая ам.долларын УХСХ байгуулсан. Түүнчлэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А-83 дугаар тушаалаар тус хөнгөлөлтийн нэг хувь болгон нэмэгдүүлсэн. Энэхүү нэг хувийн хөнгөлөлтийн хүрээнд 282.5 сая ам.долларын УХСХ байгуулсан бөгөөд энэ нь өмнөх жилүүдэд байгуулсан ногоон свопын дундаж дүнгээс 1.6 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй

<sup>6</sup> <https://www.mongolbank.mn/mn/p/1601>

<sup>7</sup> Свопын хөнгөлөлтийн хувь нэмэгдэх хүртэл хугацаанд

байна. Ногоон урт хугацаат своп хэлцлийн үлдэгдэл 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 635.6 сая ам.доллар байна.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 4 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 09 дүгээр сарын 27-ны А-258 дугаар тушаалаар Банкны олон улсын зах зээл дээрээс татсан гадаад бонд, зээлийн эх үүсвэрийг банкны гадаад валютын заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрээс хасаж тооцох тухай шийдвэрлэсэн. Энэ нь дунд хугацаанд тогтвортой хөгжлийн нэн чухал хүчин зүйл болоод буй уул уурхайн бус экспортыг дэмжих чиглэлээр гадаад худалдааны санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхийн зэрэгцээ тогтвортой ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлд үргэлжлүүлэн дэмжих зорилтын хүрээнд авч хэрэгжүүлж буй бодлогын дэмжлэг юм.

4. *Ногоон барилгын зээлийн эрсдэлийн жинг бууруулах бодлогыг ногоон барилгын шалгуур /BestGER/-тай уялдуулан хэрэгжүүлэх чиглэлээр Монголбанкнаас ямар бодлого, зохицуулалт, журам, арга хэмжээг бодитоор хэрэгжүүлсэн, эдгээр зохицуулалт өнөөдрийн байдлаар бодит практикт хэрхэн хэрэгжисж байгаа, эрсдэлийн жинг бууруулсан эсэх, хэрэв бууруулсан бол аль төрлийн зээлд, ямар шалгуур, ангиллын хүрээнд хамаарч байгаа, мөн уг бодлогын өөрчлөлт нь арилжааны банкнуудын зээлийн бодлого, зээлийн өртөг, зээлийн нөхцөл, санхүүжилтийн хүртээмжид бодитоор ямар нөлөөлөл үзүүлсэн талаар бодит тоон үзүүлэлт, баримтад тулгуурласан нэгдсэн тайлан, мэдээлэл;*

*Биелэлт:* Монголбанкнаас банкны салбарын ногоон зээл олголтыг нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн А-117 дугаар тушаалаар “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын хавсралтад “Ногоон барилгын зээл”-ийг нэмж, харгалзах активын эрсдэлийн жинг 75 хувиар тогтоох шийдвэрийг гаргасан. Ногоон барилгын зээл нь Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталсан Монгол Улсын ногоон таксономийн 4 дэх ерөнхий чиглэлийн 4.1.1-д заасан, тус заалтад тусгагдсан стандартыг хангасныг хөндлөнгийн мэргэшсэн этгээд баталгаажуулсан ногоон орон сууц худалдан авах эсвэл барих зорилго бүхий төгрөгөөр олгосон зээл байна. Энэ оны эцсийн байдлаар нийт ногоон барилгын зээлийн 98.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлд 75 хувийн эрсдэлийн жинг байгуулж, банкны системийн эрсдэлээр жигнэсэн активын үлдэгдлийг 25.0 тэрбум төгрөгөөр бууруулсан. Ингэснээр банкны зээлийн багцын эрсдэлийн бүтцийг сайжруулах, ногоон барилгын зээл олгох боломжийг нэмэгдүүлсэн.

Харин Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс ногоон барилгын "BestGER" стандартыг "Ногоон таксономи"-ийн ногоон барилгын шалгуурт тусгаагүй, "BestGER" стандартыг хангасан зээлийн чанарын хугацааны цуваа хангалтгүй тул эрсдэлийг үнэлэх боломжгүй, тус зээлийн онцлог, эрсдэлийг үнэлэх аргачлал байхгүй тул одоогоор хяналт

тавих тогтолцоо бүрдээгүй байна. Иймд "BestGER" стандартыг хангасан зээлийн үлдэгдлийн активд тооцох эрсдэлээр жигнэсэн активыг бууруулах нөхцөл хараахан бүрдээгүй байна.

5. *Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журамд ногоон барилгын шалгуур /BestGER/, эрчим хүчний хэмнэлтийн үнэлгээний үзүүлэлтийг тусган, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцанд бодит давуу байдал олгох зохицуулалтыг хэрэгжүүлэх чиглэлээр Монголбанкнаас ямар бодлого, зохицуулалт, журам, арга хэмжээг бодитоор хэрэгжүүлсэн, ипотекийн зээл олгох байршилыг хот байгуулалтын бодлоготой уялдуулан тодорхойлж байгаа эсэх, эдгээр бодлогын өөрчлөлт өнөөдрийн байдлаар бодит практикт хэрхэн хэрэгжисэж байгаа, ипотекийн журамд оруулсан нэмэлт, өөрчлөлт, үүний үр дүнд эрчим хүчний хэмнэлттэй орон сууц худалдан авсан иргэдэд зээлийн хүү, хугацаа, нөхцөлийн хувьд бодитоор ямар давуу тал олгогдож байгаа, мөн ийм төрлийн зээлд хамрагдсан өрхийн тоо, нийт олгосон зээлийн хэмжээ, ипотекийн нийт зээлд эзлэх хувь зэрэг үзүүлэлтүүд бодит амьдрал дээр хэрхэн өөрчлөгдсөн талаар тоон мэдээлэл, баримтад тулгуурласан тайлан, мэдээлэл.*

**Биелэлт:** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас "BestGER" үнэлгээний стандартыг баталсантай холбоотойгоор бүх төрлийн амины орон сууцыг хөтөлбөрийн зээлд хамруулах зорилгоор “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-д Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А-235 дугаар тушаалаар амины орон сууцны тодорхойлолтод өөрчлөлт оруулсан. Тус өөрчлөлт орсноор аймаг, нийслэл, сумын төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдсан, орон сууцны бүх хэсэг нь бие даасан ханаар хүрээлэгдсэн, эсвэл тусгаарлах хана нь нийлсэн болон хагас нийлсэн, эгнээгээр баригдсан орон сууцны зориулалттай сууц бүхий бүх төрлийн амины орон сууц худалдан авах иргэд хөтөлбөрийн зээлд хамрагдах боломжтой болсон.

Амины орон сууц худалдан авах зориулалтаар 2025 онд нийт 857 зээлдэгчид 163.8 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өмнөх оны мөн үеэс 49 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд үүнээс орон сууцны ипотекийн хөтөлбөрийн хүрээнд 29 зээлдэгчид 3.7 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Түүнчлэн орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох, зорилтот бүлэгт түлхүү чиглүүлэх, мөн эрчим хүчний хэмнэлттэй ногоон зээлийн бүтээгдэхүүний эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг холбогдох журам, гэрээнд тусгахаар ажиллаж байгаа ба эхний ээлжид Орон сууцны санхүүжилтийн банкны тухай болон Орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төслийн хэлэлцүүлгийг Хот байгуулалт, орон сууцжуулалтын яамтай хамтран 2026 оны 3 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулаа.